

## Үйлчилгээний нөхцөл

### Нэг. Ерөнхий нөхцөл

- 1.1. [www.urbanservice.mn](http://www.urbanservice.mn) нь “Урбанлинк” ХХК /“Компани”/-ийн албан ёсны вебсайт бөгөөд Хэрэглэгч, үйлчлүүлэгчид Компанийн тухай болон Компанийн үзүүлж байгаа үйлчилгээний танилцуулга, үнийн мэдээлэл хүргэх зорилготой байна.
- 1.2. Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.3. Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлтэй сайтар танилцах үүрэгтэй.
- 1.4. Вебсайтад байршуулсан лого, нэр зэрэг нь Компанийн өмч бөгөөд вебсайтын нэр, лого, бусад загварыг хуулах, олшруулах, дуурайх, өөр бусад хэлбэрээр ашиглахыг хориглоно.

### Хоёр. Вебсайтын үйл ажиллагаа

- 2.1. Компани [urbanservice.mn](http://urbanservice.mn) вебсайтаар дамжуулан Хэрэглэгчид Компанийн болон үйлчилгээний танилцуулга, үнэ тарифын мэдээллийг хүргэнэ. Вебсайт нь Хэрэглэгчид нээлттэй, мэдээлэл авах боломжийг олгосон байна.
- 2.2. Компани [urbanservice.mn](http://urbanservice.mn) вебсайтаар дамжуулан дараах үйлчилгээг Хэрэглэгчид санал болгоно.
  - 2.2.1. Хими цэвэрлэгээ, үйлчилгээ;
  - 2.2.2. Орон сууц, албан байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ;
  - 2.2.3. Орон сууц, үйлчилгээний талбайн түрээсийн үйлчилгээ.
- 2.3. Вебсайтын хэвийн ажиллагаа, түүний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг Компани бүрэн хариуцна.
- 2.4. Мэдээллийн нууцлалтай холбоотой харилцааг Нууцын бодлогод заасны дагуу зохицуулна.

### Гурав. Захиалга өгөх, баталгаажуулах

- 3.1. Хэрэглэгч нь үйлчилгээ авах хүсэлтээ вебсайт дээрх Захиалгын хуудсаар болон 77397070 утсаар эсхүл [www.facebook.com/theurbanservice/](https://www.facebook.com/theurbanservice/) фэйсбүүк хуудаст хандан илгээх боломжтой.
- 3.2. Хэрэглэгч Захиалгын хуудаст өөрийн овог, нэр, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, авах гэж буй үйлчилгээний төрөл зэрэг бусад шаардлагатай мэдээллийг үнэн зөв бөглөж Захиалгын хүсэлт илгээнэ.
- 3.3. Захиалгын хуудас дээрх мэдээллийн үнэн зөвийг Хэрэглэгч хариуцна.
- 3.4. Компани Хэрэглэгчийн Захиалгын хүсэлтийг хүлээж авч, захиалгыг баталгаажуулан холбогдох утсаар мэдээлэл өгнө.
- 3.5. Хэрэглэгч үйлчилгээний төлбөр тооцоог хийснээр үйлчилгээ авах эрх үүснэ.

### Дөрөв. Хэрэглэгчийн санал, хүсэлт, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

- 4.1. Хэрэглэгч үйлчилгээ болон вебсайтын талаар санал, гомдол, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх, илгээх эрхтэй байна.
- 4.2. Хэрэглэгч нь өөрийн санал, хүсэлт, гомдлыг 77397070 утсаар эсхүл [info@urbanservice.mn](mailto:info@urbanservice.mn) / [info@urbanlink.mn](mailto:info@urbanlink.mn) хаягаар ирүүлж болно.
- 4.3. Хэрэглэгчээс ирүүлсэн гомдлыг судалж, хянасны үндсэн дээр шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

- 4.4. Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, бусад маргаантай асуудлыг энэхүү Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлого болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

**Тав. Бусад**

- 5.1. Компани нь энэхүү Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр [urbanservice.mn](http://urbanservice.mn) вебсайт дээр нийтэд нээлттэй байдлаар нийтлэх бөгөөд Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлтэй танилцах үүрэг хүлээнэ.
- 5.2. Хэрэглэгчийг үйлчилгээ авах захиалга хийгдэх үед мөрдөгдөж байсан үйлчилгээний нөхцөл үйлчилгээ үзүүлэх шатанд өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх Үйлчилгээний нөхцөлийг үйлчилгээг үзүүлж дуусах хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

--o0o--